

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/042/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Говьсүмбэр аймаг  
2025 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543179  
Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)  
Аудитын менежер: Г.Наранбаяр  
Цахим хаяг: [baranbayarg@audit.gov.mn](mailto:baranbayarg@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Анхтуяа  
Цахим хаяг: [ankhtuyab@audit.gov.mn](mailto:ankhtuyab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviumber@audit.gov.mn

Г ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Ш.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2025.02.21 № 25  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

422502088

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>306,163,811.31</b>	<b>780,437,644.81</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	10,526,271.00	299,868,890.74
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	10,526,271.00	299,868,890.74
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	10,526,271.00	299,868,890.74
31211	Төрийн сангийн харилцах	00.00	259,541,979.74
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	10,526,271.00	40,326,911.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,900,894.52	7,460,688.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	540,894.52	1,180,687.63
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,280,000.00	6,280,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	80,000.00	00.65
3351	Байгууллагаас авах авлага	80,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	00.65
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	5,879,179.00	5,879,179.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	5,879,179.00	5,879,179.00
34713	Цалингийн урьдчилгаа	5,879,179.00	5,879,179.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	282,857,466.79	467,228,886.79
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	282,857,466.79	467,228,886.79
35410	Бичиг хэргийн материал	501,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	278,133,276.78	457,017,276.78
35460	Хүнсний материал	4,223,190.01	10,211,610.01
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,849,771,091.47</b>	<b>4,541,835,116.73</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,849,771,091.47	4,541,835,116.73
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,641,835,091.47	4,333,899,116.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,898,012,275.23	3,898,012,275.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-593,872,378.80	-712,646,854.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,502,075.00	71,502,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-71,502,075.00	-71,502,075.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,521,933,906.20	3,261,088,906.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,293,387,444.64	-2,365,453,789.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	399,055,761.00	575,305,761.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-352,452,165.43	-383,562,319.14
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,166,666.89	-13,166,666.93
39217	Ном	53,711,804.80	54,321,804.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	207,936,000.00	207,936,000.00
39301	Програм хангамж	9,090,995.00	9,090,995.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-9,090,995.00	-9,090,995.00
39303	Бусад биет бус хөрөнгө	209,886,000.00	209,886,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,950,000.00	-1,950,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,155,934,902.78</b>	<b>5,322,272,761.54</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>15,323,998.83</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	15,323,998.83
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	15,323,998.83
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	15,310,628.38
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	13,370.45

41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	13,370.45
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,155,934,902.78</b>	<b>5,306,948,762.71</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,155,934,902.78	5,306,948,762.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,681,905,393.60	3,681,905,393.60
51101	Өмч: - төрийн	3,681,905,393.60	3,681,905,393.60
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-277,970,254.51	873,043,605.42
51210	Өмнөх үеийн үр дүн	-277,970,254.51	-277,970,254.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,151,013,859.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	751,999,763.69	751,999,763.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,155,934,902.78</b>	<b>5,322,272,761.54</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,251,324,556.00</b>	<b>5,251,164,700.06</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>31,163,000.00</b>	<b>1,060,192,000.06</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	31,163,000.00	1,060,192,000.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,388,000.00	42,627,000.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	42,627,000.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,388,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,220,161,556.00</b>	<b>4,190,972,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,634,113,900.00	3,537,472,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,634,113,900.00	3,537,472,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	33,254,156.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,254,156.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	552,793,500.00	653,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	552,793,500.00	653,500,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,515,966,517.38</b>	<b>4,100,150,840.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,515,966,517.38</b>	<b>4,100,150,840.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,001,644,610.48	3,874,847,131.60
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,577,150,600.54	2,313,234,464.43
210101	Үндсэн цалин	1,021,480,553.48	1,497,621,807.70
210102	Нэмэгдэл	368,292,294.06	629,805,647.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,436,000.00	64,110,000.00
210104	Урамшуулал	122,941,753.00	121,697,009.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	224,168,162.55	283,569,264.30
210201	Тэтгэврийн даатгал	152,916,689.61	195,768,348.66
210202	Тэтгэмжийн даатгал	17,890,546.78	23,167,100.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,308,037.35	12,115,191.58
210204	Ажилгүйдлийн даатгал	3,552,803.77	10,799,834.98
210205	Эрүүл мэндийн даатгал	35,500,085.04	41,718,788.28

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	525,792,937.28	646,232,258.69
210301	Гэрэл, цахилгаан	40,619,877.01	40,788,625.81
210302	Түлш, халаалт	413,630,728.25	528,991,886.92
210303	Цэвэр, бохир ус	71,542,332.02	76,451,745.96
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	155,205,679.18	85,608,657.60
210401	Бичиг хэрэг	43,313,850.00	28,605,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,311,337.00	10,800,379.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,444,835.39	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,100,600.00	27,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,532,478.00	46,175,578.60
210408	Бараа материал акталсны зардал	67,502,578.79	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	118,889,663.50	113,610,090.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,604,530.00	3,468,510.00
210502	Хоол, хүнс	116,285,133.50	110,141,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	99,849,190.00	99,811,011.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,394,100.00	5,308,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	3,318,500.00
210604	Урсгал засвар	92,455,090.00	91,184,211.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,808,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,808,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,442,682.42	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,775,126.42	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,019,400.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	608,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,156.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	287,337,695.01	332,781,385.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,570,000.00	48,634,635.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,905,000.00	60,195,775.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	242,862,695.01	223,950,974.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	514,321,906.90	225,303,708.53
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	95,669,100.00	224,035,967.22
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,051,800.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,038,400.00	53,405,967.22
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	73,112,700.00	162,245,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,466,200.00	8,385,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	395,652,244.18	1,267,741.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	395,652,244.18	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	23,000,562.72	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,000,562.72	00.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>-264,641,961.38</b>	<b>1,151,013,859.93</b>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>-264,641,961.38</b>	<b>1,151,013,859.93</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,234,270,190.40</b>	<b>4,273,130,340.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,388,000.00</b>	<b>82,157,640.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,388,000.00	82,157,640.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	10,388,000.00	82,157,640.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	42,707,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,388,000.00	39,450,640.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,223,882,190.40</b>	<b>4,190,972,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,634,113,900.00	3,537,472,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,634,113,900.00	3,537,472,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	36,974,790.40	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,974,790.40	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	552,793,500.00	653,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	552,793,500.00	653,500,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3221211846.60</b>	<b>3983177720.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,221,211,846.60</b>	<b>3,983,177,720.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,706,089,939.70</b>	<b>3,757,874,011.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,575,279,288.06	2,336,352,591.81
210101	Үндсэн цалин	1,019,646,123.66	1,416,990,178.74
210102	Нэмэгдэл	369,083,847.47	707,877,079.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,419,005.21	90,120,873.67
210104	Урамшуулал	122,130,311.72	121,364,460.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	224,168,162.55	284,767,571.85
210201	Тэтгэврийн даатгал	152,916,689.61	190,821,493.56
210202	Тэтгэмжийн даатгал	17,890,546.78	23,583,580.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,308,037.35	11,870,641.40
210204	Ажилгүйдлийн даатгал	3,552,803.77	11,694,430.14
210205	Эрүүл мэндийн даатгал	35,500,085.04	46,797,425.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	525,792,937.28	646,232,258.69
210301	Гэрэл, цахилгаан	40,619,877.01	40,788,625.81
210302	Түлш, халаалт	413,630,728.25	528,991,886.92

210303	Цэвэр, бохир ус	71,542,332.02	76,451,745.96
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43,971,789.39	00.00
210401	Бичиг хэрэг	9,077,350.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	10,768,837.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,160,802.39	00.00
210404	Ном, хэвлэл	701,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,100,600.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,162,900.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	112,393,779.00	114,510,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,604,530.00	00.00
210502	Хоол, хүнс	109,789,249.00	114,510,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,959,790.00	24,240,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,353,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,407,000.00	8,253,100.00
210604	Урсгал засвар	19,199,790.00	15,987,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,808,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,808,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,830,715.42	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,860,126.42	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	873,400.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	856,033.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,156.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	183,885,478.00	351,770,139.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,660,000.00	185,480,789.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	171,225,478.00	166,289,350.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>515,121,906.90</b>	<b>225,303,708.53</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	96,469,100.00	224,035,967.22
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,445,400.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,038,400.00	53,405,967.22
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	73,112,700.00	162,245,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,872,600.00	8,385,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	395,652,244.18	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	395,652,244.18	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	23,000,562.72	1,267,741.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,000,562.72	1,267,741.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>13,058,343.80</u></b>	<b><u>289,952,619.74</u></b>

	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>3,221,211,846.60</u></b>	<b><u>3,983,177,720.26</u></b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,341,499.80</b>	<b>610,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,341,499.80</b>	<b>610,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	15,341,499.80	610,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,341,499.80	610,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-15,341,499.80</u></b>	<b><u>-610,000.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>3,221,211,846.60</u></b>	<b><u>3,983,177,720.26</u></b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-2,283,156.00	289,342,619.74
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	12,809,427.00	10,526,271.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	10,526,271.00	299,868,890.74

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	3,473,969,393.60	00.00	2,434,213,815.04	00.00	5,908,183,208.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,473,969,393.60</b>	<b>00.00</b>	<b>2,434,213,815.04</b>	<b>00.00</b>	5,908,183,208.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,005,616,816.73	00.00	-1,005,616,816.73
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,681,905,393.60</b>	<b>751,999,763.69</b>	<b>-277,970,254.51</b>	<b>00.00</b>	4,155,934,902.78
D01	<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>3,681,905,393.60</b>	<b>751,999,763.69</b>	<b>-277,970,254.51</b>	<b>00.00</b>	4,155,934,902.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,681,905,393.60</b>	<b>751,999,763.69</b>	<b>-277,970,254.51</b>	<b>00.00</b>	4,155,934,902.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,151,013,859.93	00.00	1,151,013,859.93
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,681,905,393.60</b>	<b>751,999,763.69</b>	<b>873,043,605.42</b>	<b>00.00</b>	5,306,948,762.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		10,526,271.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,225,106,500.00	3,982,519,978.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,225,106,500.00	3,982,519,978.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,000,870,800.00	3,758,484,011.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,402,982,000.00	2,336,352,591.81
210101	Үндсэн цалин	1,517,386,900.00	1,416,990,178.74
210102	Нэмэгдэл	769,188,000.00	707,877,079.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	116,407,100.00	90,120,873.67
210104	Урамшуулал	00.00	121,364,460.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	300,372,700.00	284,767,571.85
210201	Тэтгэврийн даатгал	204,253,500.00	190,821,493.56
210202	Тэтгэмжийн даатгал	24,029,800.00	23,583,580.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,014,900.00	11,870,641.40
210204	Ажилгүйдлийн даатгал	12,014,900.00	11,694,430.14
210205	Эрүүл мэндийн даатгал	48,059,600.00	46,797,425.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	647,500,000.00	646,232,258.69
210301	Гэрэл, цахилгаан	45,000,000.00	40,788,625.81
210302	Түлш, халаалт	527,500,000.00	528,991,886.92
210303	Цэвэр, бохир ус	75,000,000.00	76,451,745.96
2105	Нормативт зардал	162,239,000.00	114,510,750.00
210502	Хоол, хүнс	162,239,000.00	114,510,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,763,300.00	24,240,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	26,774,500.00	8,253,100.00
210604	Урсгал засвар	15,988,800.00	15,987,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	445,013,800.00	352,380,139.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	214,753,200.00	186,090,789.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	230,260,600.00	166,289,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	224,235,700.00	224,035,967.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	224,235,700.00	224,035,967.22
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,457,700.00	53,405,967.22
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	157,672,000.00	162,245,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,106,000.00	8,385,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,225,106,500.00</b>	<b>4,271,862,598.69</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,537,472,700.00</b>	<b>3,537,472,700.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,537,472,700.00	3,537,472,700.00

<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>653,500,000.00</b>	<b>652,232,258.69</b>
132001	Орон нутгийн төсвөөс	653,500,000.00	652,232,258.69
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>34,133,800.00</b>	<b>42,707,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,133,800.00	42,707,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	<b>10,526,271.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	<b>299,868,890.74</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>83.00</b>	<b>79.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	52.00	49.00
620003	Үйлчлэх ажилтан	30.00	29.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

## Гурав. Аудитын илрүүлэлт:

### Завсрын аудитаар:

Тус байгууллагад 2024 оны 2 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 10 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 409,072.7 мянган төгрөгийн 6 алдааг залруулах зөвлөмж өгсөн байна. Нийт 409,072.7 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 15,945.0 мянган төгрөгийн 9 тушаал шийдвэр, цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 15,382.0 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, 5-н сая төгрөгөөс дээш 185,587.1 мянган төгрөгийн худалдан авалт тус тус мэдээлээгүй нийт 216,914.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн, Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж өмнөх 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн *"Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 7 тушаал шийдвэр, цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш орлогын 4, зарлагын 2 гүйлгээ, тендерийн мэдээлэл зэрэг нийт 124,437.3 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй"* зөрчлийг давтан гаргасан, 2024.02.17-ны өдрийн 22/А0861082 дугаартай албан шаардлагыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.13, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.2.10, 3.2.11 дэх заалтуудтай нийцээгүй, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д *"Шалгаагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах.."*, 19.2-т *"Шалгаагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана"* гэж тус тус заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан, хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй тул нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар нийт 39,450.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 39,450.6 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

**Залруулсан алдаа:**

1. Жилийн эцсээр ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн 39,450.6 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч алдаатай бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой" ангилал батламж мэдэгдлийг хангаагүй.

**Залруулаагүй алдаа:**

Байхгүй

Аудитаар нийт 27,358.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 13,173.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,484.6 мянган төгрөгийн албан шаардлага, 12,700.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

**Төлбөрийн акт**

1. Гурав дахь жил тутамд олгодог нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажилласан жилийн шаардлага хангаагүй, тэтгэмж авах хугацаа болоогүй байхад эрх мэдлээ хэтрүүлэн өөртөө шийдвэр гаргаж, тэтгэмж авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.3.3, Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам" -ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.1.3, 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Нийт 2 ажилтанд төрийн өмчийн байрыг үнэ төлбөргүй ашиглуулж, төрийн өмчийг үнэгүйдүүлсэн 684.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 20.2, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 28.5, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын 2, 3 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

3. Цалин, ээлжийн амралт давхардуулан 44 албан хаагчид 3,645.7 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### **Албан шаардлага**

1. Нийт 2 албан хаагчаас 1,105.1 мянган төгрөгийн НДШ илүү суутгасан, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагчийг НДШ-ийн тайланд код зөрүүтэй оруулснаар 379.5 мянган төгрөг илүү тайлагнасан нийт 1,484.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.3, 20.2.4-, 20.2.5, 20.2.7, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС 39-Ажилтны тэтгэмж дахь заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан, шимтгэл илүү төлсөн зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### **Зөвлөмж**

1. Авлага данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Авлага дансанд эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, насжилт өндөр, найдваргүй 12,700.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан, авлага барагдуулах талаар арга хэмжээ аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Найдваргүй, насжилт өндөртэй авлагыг барагдуулах чиглэлээр захирлын тушаалаар ажлын хэсэг томилох, ажлын хэсэг төлөвлөгөө гаргаж батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, гүйцэтгэлийг тайлагнах

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж	7	448.5	2	150.3	5	298.3	7	448.5				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>448.5</b>	<b>2</b>	<b>150.3</b>	<b>5</b>	<b>298.3</b>	<b>7</b>	<b>448.5</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж	5	27.4	3	13.2	1	1.5	1	12.7				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>27.4</b>	<b>3</b>	<b>13.2</b>	<b>1</b>	<b>1.5</b>	<b>1</b>	<b>12.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж	1	216.9			1	216.9		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>216.9</b>			<b>1</b>	<b>216.9</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>216.9</b>			<b>1</b>	<b>216.9</b>		

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			